

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

20.... оны .....-р сарын .....-ны өдөр

Дугаар \_\_\_\_/\_\_\_\_

Улаанбаатар хот

Журам, аргачлал батлах тухай

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам”-ыг нэгдүгээр, “Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцох аргачлал”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого, зохицуулалтын газар /Ш.Мягмар/, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н.Цагаанхүү/, Аймаг, нийслэлийн байгаль орчны газар, Сав газрын захиргаадад тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд,

4. Сангийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А-299/204 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД

САНГИЙН САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Ч.ХҮРЭЛБААТАР

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Сангийн сайдын 20...оны .... дугаар сарын ..... -  
ний өдрийн \_\_\_\_/\_\_\_\_ дугаар хамтарсан  
тушаалын 1 дүгээр хавсралт

## **Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Журмын зорилго нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ус бохирдуулагчийн хаягдал усны эзлэхүүн болон хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтооход оршино.

1.2. Тус журам нь ус бохирдуулагчийн хаягдал усны хэмжээг тооцох болон хоногт 50 шоо метрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагч нарт хамаарна.

1.3. Энэхүү журам нь хаягдал усны дүгнэлт гаргах, хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгох, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулах, ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр ногдуулахад үндэслэл болгоно.

1.4. Ус бохирдуулагчийн хаягдал усны чанар нь Хүрээлэн байгаа орчин, усны чанар, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015, Хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015, Арьс ширний үйлдвэрүүд Харгиа цэвэрлэх байгууламжид хаягдал усаа нийлүүлэх MNS 5582:2006 стандартаар тогтоосон норм, нормативыг хангасан тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн хаясан тохиолдолд нөхөн төлбөр болно.

1.5. Журмын хэрэгжилтэд усны сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын эрх бүхий байцаагч, байгаль хамгаалагч хяналт тавина.

### **Хоёр. Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын хэмжээг тодорхойлох**

2.1. Хаягдал усны эзлэхүүнийг тооцох

2.1.1. Ус бохирдуулагчийн тухайн улиралд татан зайлуулж байгаа хаягдал усны эзлэхүүнийг хаягдал усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тогтооно.

2.1.2. Энэ журмын 2.1.1-т заасан хэмжих хэрэгсэлгүй, эсхүл хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд хаягдал усны эзлэхүүнийг цэвэр усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тооцно.

2.1.3. Уг журмын 2.1.1, 2.1.2-т заасан хэмжих хэрэгсэлгүй эсхүл суурилуулаагүй болон хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдсан үед хаягдал усны хэмжээг тооцохдоо Усны тухай хуулийн 10.1.3-т заасан усны

хэрэглээний нормыг ашиглан тооцно.

2.1.4. Хаягдлын сантай, хаягдал усыг технологийн зориулалтаар эргүүлэн ашигладаг уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэл эрхэлж байгаа ус бохирдуулагчийн хаягдал усны эзлэхүүнийг нөхөн сэлгэлтээр ашигласан усны эзлэхүүнд үндэслэн тооцно.

2.1.5. Нөхөн сэлгэлтээр ашигласан усны эзлэхүүнийг цэвэр усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тооцож болно.

2.1.6. Энэхүү журмын 2.1.4-т заасан нөхөн сэлбэлтээр ашигласан усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэлгүй тохиолдолд техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ болон ус ашиглах дүгнэлт, тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө зэрэгт үндэслэн нөхөн сэлгэж ашигласан усны эзлэхүүнийг тооцно.

2.1.7. Гадаргын ус ашиглан /драгаар/ алт олборлодог ус бохирдуулагчийн хаягдал усны хэмжээг технологид ашиглаж байгаа нийт усны эзлэхүүнээр тооцно.

2.1.8. Газрын тос олборлох үйлдвэрлэлийн хаягдал усны хэмжээг зүмп болон хаягдлын сангийн эзлэхүүнээр тооцож болно.

2.1.9. Хоногт 1 шоо метр болон түүнээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчийг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэгт зааснаар зохицуулна.

2.2. Хаягдал усан дахь бохирдуулагч бодисын хэмжээг тооцох

2.2.1. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг “Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцох аргачлал”-ын дагуу тооцно.

2.2.2. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоохдоо байгалийн усны найрлагыг суурь болгох бөгөөд тус хэмжээнээс давсан үзүүлэлтийг бохирдуулах бодисын хэмжээ гэж үзнэ.

2.2.3. Энэхүү журмын 2.2.3, 2.2.4-т заасан хуулийн этгээд болон бусад ус бохирдуулагчийн хаягдал усанд агуулагдах ус бохирдуулагч бодисын хэмжээг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнд үндэслэнэ.

2.2.4. Хоногт 50 шоо метр хүртэл, аюултай бохирдуулах бодис агуулаагүй хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчийн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг жишиг хэмжээгээр тооцно.

### **Гурав. Хаягдал усны сорьц авах цэг тогтоох**

3.1. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл сав газрын захиргаа нь хаягдал усны сорьц авах хяналтын цэгийг тогтоох бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага бүр тогтоосон цэгт хаягдал усны сорьц авах хяналтын цэгийг “Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт. 10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж” MNS\_ISO 5667-10:2001 стандартад нийцүүлэн байгуулна.

3.2. Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбогдсон хуулийн этгээд хаягдал усны сорьц авах цэгийг хаягдал ус төвийн шугамд орохын өмнөх хэсэгт байршуулна.

3.3. Хаягдлын сантай, хаягдал усыг технологийн зориулалтаар эргүүлэн ашигладаг олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн хаягдал усны сорьц авах цэгийг хаягдлын сангаас гарах хэсэг эсхүл эргэлтийн усан санд орох хэсэгт тогтооно.

3.4. Гадаргын ус ашиглан /драгаар/ алт олборлодог хуулийн этгээд технологийн ус хуримтлуулах далангийн аль ч хэсэгт хаягдал усны сорьц авах цэгийг тогтоож болно.

3.5.Газрын тос олборлох үйлдвэрлэлийн бохирдуулах бодисын хэмжээг зүмп болон хаягдлын санд усны сорьц авах цэгийг тогтоож болно

### **Дөрөв. Ус бохирдуулагч хуулийн этгээдийн эрх, үүрэг**

4.1. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2-д заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулж, дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

4.2. Сорьц авах цэгийг хаягдал усны гаргалгаа бүр дээр MNS ISO 5667-10:2001 стандартад заасны дагуу тогтоож, бохирдлын эх үүсвэрт үзлэг, шалгалт хийх нөхцөлөөр хангана.

4.3. Хоногт 50 шоометрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагч нь сар бүр хаягдал усны сорьцод Усны тухай хуулийн 25.2-т заасан байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, дүнг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор харьяа Сав газрын захиргаанд хүргүүлнэ.

4.4. Хоногт 50 шоометрээс бага, аюултай бохирдуулах бодис агуулаагүй хаягдал ус гаргадаг ус бохирдуулагч хуулийн этгээд хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг жишиг хэмжээгээр тооцох нь үндэслэлгүй гэж үзвэл хаягдал усан дахь бохирдуулах бодис тус бүрийн хэмжээгээр ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг төлж болно.

4.5. Хот суурины хангагч байгууллагын ариутгах татуургад хаягдал бохир усаа нийлүүлдэг аж ахуйн нэгжүүд тус байгууллагын хаягдал усны дүгнэлтийг үндэслэн хаягдал усны зөвшөөрөл авна.

### **Тав. Хяналт тавих, мэдээллийн санд бүртгэх**

5.1. Мэргэжлийн хяналтын байгууллага дараах хяналтыг хэрэгжүүлнэ.

5.1.1. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд тогтоосон цэгээс ус бохирдуулагчийн төлөөллийг байлцуулан авсан сорьцыг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн хаягдал усны чанар, найрлага нь стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

5.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал усны чанар, найрлагад мэргэжлийн хяналтын байгууллага төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх бөгөөд хаягдал усны чанар, найрлага стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд энэ тухай мэдээллийг харьяалах Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны албанд мэдэгдэнэ.

5.1.3. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч ус бохирдуулагчийн тухайн улиралд зайлуулж байгаа хаягдал усны эзлэхүүнийг хаягдал усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалт болон хаягдал усны дүгнэлтэд үндэслэн хяналт тавьж, хяналтын дүн мэдээг тоолуурын заалт авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Сав газрын захиргаанд хүргүүлнэ.

5.1.4. Энэ журмын 5.1.2-т заасан шалгалтаар хаягдал усны чанар, найрлага нь стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн нь тогтоогдсон аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн хяналтын байгууллага зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгч, тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагад Усны тухай хуулийн 25.2-т заасны дагуу улсын байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр нэмэгдүүлж ногдуулна.

5.1.5. Татварын алба нь энэ журмын 5.1.3-т заасан мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн тогтоосон ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг ногдуулна.

5.2. Сав газрын захиргаа дараах хяналтыг хэрэгжүүлнэ.

5.2.1. Усны бохирдлын эх үүсвэр, эзлэхүүн, хаягдал усан дахь бохирдуулах бодисын агууламжийг бохирдуулагч бодис тус бүрээр хянан, дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, хяналт шинжилгээний дүнг нэгтгэн улсын усны мэдээллийн санд 11 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлнэ.

5.2.2. Сав газрын захиргаа нь ус бохирдуулсны төлбөрийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.

5.2.3. Сав газрын захиргаа ус бохирдуулагчид гаргасан хаягдал усны дүгнэлтийг сум, дүүргийн засаг даргад хүргүүлнэ.

5.2.4. Аж ахуйн нэгж байгууллагад олгосон хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийн мэдээллийг сар бүрийн 01-ний дотор аймаг, нийслэлийн байгаль орчны албанд мэдээлнэ.

5.2.5. Усны бохирдлын томоохон эх үүсвэрийн мэдээлэл (бохирдуулагч, хаяг, байршил, усны объект, хаягдал усны хэмжээ, горим, цэвэрлэх байгууламжийн төрөл, ажиллагаа, найрлага чанар, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл)-ийг улсын усны мэдээллийн санд 11 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлнэ.

5.2.6. Хаягдал усны дахин ашиглалтын талаарх мэдээлэл, аймаг, нийслэл, сум дүүргээр (дахин ашиглагчийн нэр, хаяг, байршил, дахин ашиглахад хэрэглэсэн технологи, дахин ашиглалтын хэмжээг тогтоосон байгууллага, усны хэмжээ, чанар, хэмнэсэн ус) бүртгэл хөтөлж, улсын усны мэдээллийн санд 11 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлнэ.

5.3. Аймаг, нийслэлийн байгаль орчны алба дараах хяналтыг хэрэгжүүлнэ.

5.3.1. Ус бохирдуулагчид олгосон хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийг бүртгэл хөтөлж, сар бүрийн 05-ны дотор аймаг нийслэлийн татварын албанд болон усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.

5.3.2. Усны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-д заасны дагуу хаягдал ус зайлуулах цэгийн мэдээллийг аймаг, нийслэлийн хэмжээнд нэгтгэж усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5.3.3. Хаягдал ус зайлуулалтын мэдээлэл (хаягдал усны хэмжээ, найрлага, бохирдуулах бодисын хэмжээ, цэвэрлэгээний төрөл, төлбөр хураамж төлөлт, хөнгөлөлт-улирал, жил), аймаг, нийслэл, сум дүүргээр бүртгэж улсын усны мэдээллийн санд 11 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлнэ.

5.3.4. Хаягдал усны дахин ашиглалтын талаарх мэдээлэл, аймаг, нийслэл, сум дүүргээр (дахин ашиглагчийн нэр, хаяг, байршил, дахин ашиглахад хэрэглэсэн технологи, дахин ашиглалтын хэмжээг тогтоосон байгууллага, усны хэмжээ, чанар, хэмнэсэн ус, төлбөр) бүртгэл хөтөлж, улсын усны мэдээллийн санд 11 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлнэ.

## Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоолох аргачлал

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хаягдал усны эзлэхүүн болон хоногт 50 шоо метрээс их хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоход энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Бохирдуулах бодисын агууламжийг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний сарын дундаж дүнг ашиглана.

### Хоёр. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тодорхойлох

2.1. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.1-т заасан үндсэн үзүүлэлтийн дагуу холбогдох стандартын бүх үзүүлэлтээр гаргах бөгөөд тухайн үйлдвэрлэл үйлчилгээний онцлогийг харгалзан эрдэс бодис, голлох органик бодис, хүнд металл болон аюултай бохирдуулах бодисын үзүүлэлтээр гаргана.

2.2. Үйлдвэрлэл үйлчилгээнээс гарах хаягдал хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисыг Хүрээлэн байгаа орчин, усны чанар, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015 стандартын С хавсралтад үндэслэн тооцно.

2.2. Хаягдал усан дахь бохирдуулах бодис: жинлэгдэх бодис, органик бодис, эрдэс бодис, хүнд металлын хэмжээг дараах томъёо (1)-г ашиглан тооцно.

$$M_i = V_{\text{ул}} * C_i$$

томъёо (1)

$M_i$  – хаягдал усны холимог дээжин дэх бохирдуулах бодис/жинлэгдэх бодис, органик, эрдэс бодис, хүнд металл/-ын хэмжээ (кг);

$V_{\text{ул}}$  – ус бохирдуулагчаас тухайн улиралд ( $V_{\text{ул}}$ ) зайлуулж буй хаягдал усны эзлэхүүн, ( $\text{м}^3$ );

$C_i$  – хаягдал усны холимог дээжин дэх  $i$  бохирдуулах бодисын дундаж агууламж, ( $\text{кг}/\text{м}^3$ );

$i$  – Жинлэгдэх, органик, эрдэс, бодис, хүнд металл.

2.3. Хаягдал усны холимог дээжин дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг томъёо (2) ашиглан тооцно.

$$C_i = \sum_{i=1}^n C_i$$

томъёо (2)

$C_i$  – Хаягдал усны холимог дээжин дэх  $i$  бохирдуулах бодисын дундаж ( $\text{мг}/\text{л}$ );  
 $n \geq 2$  – Улиралд хийх шинжилгээний давтамж.

### 3. Хаягдал усны эзлэхүүнийг тооцох

3.1. Улиралд зайлуулж буй хаягдал усны эзлэхүүнийг ( $Q_{ул}$ ) бохир усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тогтооно.

$$V_{ул} - \text{Хаягдал усны тоолуурын заалт, м}^3 \quad \text{томьёо (3)}$$

3.2. Хэмжих хэрэгсэлгүй, эсхүл суурилуулаагүй болон хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдсан үед хаягдал усны эзлэхүүнийг тооцохдоо цэвэр усны шугам дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тогтооно.

$$V_{ул} = V_{ул \text{ цэв}} \quad \text{томьёо (4)}$$

$V_{ул}$  - Хаягдал усны тоолуурын заалт, м<sup>3</sup>

$V_{ул \text{ цэв}}$  - цэвэр усны шугам дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалт, м<sup>3</sup>

3.3. Хэмжих хэрэгсэлгүй эсхүл суурилуулаагүй болон хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдсан үед хаягдал усны хэмжээг тооцохдоо Усны тухай хуулийн 10.1.3-т заасан усны хэрэглээний нормыг ашиглан тодорхойлсон усны эзлэхүүнээс үйлдвэрлэл, үйлчилгээний бүтээгдэхүүнд шингэсэн усны хэмжээг хасаж гаргана.

$$V_{ул} = V_{ул \text{ цэв}} - V_{ул \text{ бүт}} \quad \text{томьёо (5)}$$

$V_{ул}$  - Хаягдал усны тоолуурын заалт, м<sup>3</sup>

$V_{ул \text{ цэв}}$  - технологийн цэвэр усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тодорхойлсон усны эзлэхүүнээс үйлдвэрлэл, үйлчилгээний бүтээгдэхүүнд шингэсэн усны хэмжээг хасаж гаргана.

$V_{ул \text{ бүт}}$  - үйлдвэрлэл үйлчилгээний бүтээгдэхүүнд шингэсэн усны хэмжээ, (м<sup>3</sup>).

### 4. Хаягдал усан дахь аюултай бохирдуулах бодисын агууламжийг тооцох

4.1. Хаягдал усан дахь аюултай бохирдуулах бодисын агууламжийг дараах томьёогоор тооцоолно.

$$M_k = V_{ул} * C_k \quad \text{томьёо (6)}$$

$M_k$  - хаягдал усны холимог дээжин дэх аюултай бохирдуулах бодисын агууламж, (гр)

$V_{ул}$  - ус бохирдуулагчаас тухайн улиралд зайлуулж буй хаягдал усны эзлэхүүн, (м<sup>3</sup>);

$C_k$  - хаягдал усны холимог дээжин дэх к аюултай бохирдуулах бодисын дундаж агууламж (гр/м<sup>3</sup>);

к-аюултай бохирдуулах бодис.

### 5. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын нөхөн төлбөр ногдуулах хэмжээг тодорхойлох

5.1. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан агууламжаар тооцсон бохирдуулах бодисын хэтэрсэн хэмжээнд нөхөн төлбөр ногдуулна.

5.2. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан агууламжийг дараах томъёогоор тооцно.

$$C_{i.cда} = C^i - C_{зда} \quad \text{томъёо (5)}$$

$C_{i.cда}$ -хаягдал усны холимог дээжин дэх бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан агууламж, (кг/м<sup>3</sup> буюу гр/м<sup>3</sup>)

$C^i$ -хаягдал усан дахь бохирдуулах бодисын улирлын дундаж агууламж, (кг/м<sup>3</sup> буюу гр/м<sup>3</sup>)

$C_{зда}$  – хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж, (кг/м<sup>3</sup> буюу гр/м<sup>3</sup>)

5.3. Энэ аргачлалын 5.2-т тооцсон агууламжийн хаягдал усны эзлэхүүнд ногдох бохирдуулах бодисын хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бохирдуулах бодис болно.

5.4. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэтэрсэн хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$M_{i.cда} = V_{ул} * C_{i.cда} \quad \text{томъёо (6)}$$

$M_{i.cда}$ -хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэтэрсэн хэмжээ (кг)

$C_{i.cда}$ -хаягдал усны холимог дээжин дэх бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан агууламж, (кг/м<sup>3</sup> буюу гр/м<sup>3</sup>)

5.5.Хаягдал усан дахь аюултай бохирдуулах бодисын хэтэрсэн хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$M_{кcда} = V_{ул} * C_{кcда} \quad \text{томъёо (7)}$$

$M_{кcда}$ -хаягдал усан дахь аюултай бохирдуулах бодисын хэтэрсэн хэмжээ (гр)